138.	206.	5.2.6.Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэр байгуулна. (ЗГҮАХ-2.72.3, ТАҮТББ- 4.2.3.6)	1. Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлнэ.	Тоо хэмжээ: 1 Чанар: Үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлын явцад хяналт тавьсан байна. Хугацаа: Жилдээ	ХҮБГ, УУБГ
	207.		2. Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлнэ.	Тоо хэмжээ: 1 Чанар: Үйлдвэр байгуулах бэлтгэл ажлыг хангах чиглэлээр зөвлөмж, чиглэл өгч, хяналт тавьсан байна. Хугацаа: Жилдээ	ХҮБГ
139.	208.	5.2.7. Гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулж, импортын хэмжээг бууруулна. (ЗГҮАХ-2.72.4)	1. Дотоодын төмөрлөг боловсруулах үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр санал боловсруулна .	Тоо хэмжээ:1 Дотоодын төмөрлөг боловсруулах үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр санал боловсруулсан байна. Хугацаа:Жилдээ	ХҮБГ
140.	209.	5.2.8. Автомашин, машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэр, технологийн парк байгуулахыг бодлогоор дэмжинэ. (ЗГҮАХ-2.75.1, ТАҮТББ-4.2.1.8, 4.2.4.4, 4.2.4.5)	1. Автомашин, машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэрлэл, технологийн парк байгуулахыг дэмжинэ.	Тоо хэмжээ: 1 Чанар: Парк байгуулах боломж, нөхцөлийн талаар дэлгэрэнгүй судалгаа хийх ажлыг зохион байгуулсан байна. Хугацаа: Жилдээ	ХҮБГ
141.	210.	5.2.9. Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж,	1. Дархан, Эрдэнэт болон Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн	Тоо хэмжээ: 1 удаа	

		үйлдвэрийн кластер, үйлдвэрлэл, технологийн парк, тээвэр логистикийн сүлжээг цогцоор нь төлөвлөн хэрэгжүүлэх (ТАҮТББ-4.2.3)	конторын барилгыг төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх ажлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран зохион байгуулна.	Паркуудын конторын барилгыг төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэхэд шаардлагатай материал, баримт бичгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн байна. Хугацаа: II улирал	ХҮБГ
	211.		2. Үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийг дэмжих орон нутгийн сан бүрдүүлэх чиглэлээр Дархан, Эрдэнэт, Өмнөговь болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран ажиллана.	Тоо хэмжээ: 1 удаа Үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийг дэмжих орон нутгийн санг бүрдүүлэх чиглэлээр тухайн орон нутгийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж зөвлөмж, чиглэл өгч, хамтран ажилласан байна. Хугацаа: Жилдээ	ХҮБГ
	212.		3. Үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжил, хөрөнгө оруулалтыг дэмжсэн чуулга, уулзалтыг орон нутагт зохион байгуулна.	Тоо хэмжээ: 1 удаа "Дархан ҮТП-ийн хөгжил" сэдэвт чуулга уулзалтыг Дархан-Уул аймагт зохион байгуулахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна. Хугацаа: II улирал	ХҮБГ
5.3. Газрын тос, уламжлалт бус газрын тос боловсруулах үйлдвэр, нүүрсийг хагас, гүн боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэр байгуулах, бүтээгдэхүүнийг дотоод, гадаад зах зээлд борлуулах бодлогын удирдамжаар хангах					
142.	213.	5.3.1. "Газрын тос боловсруулах үйлдвэр"-ийн дэд бүтцийн нарийвчилсан судалгаа, үйлдвэр болон дамжуулах хоолойн газрын асуудлыг шийдвэрлэнэ. (ЗГҮАХ-2.70.1, ҮЧ-4.4, ТАҮТББ-4.2.3.6)	1. "Газрын тос боловсруулах үйлдвэр"-ийн дэд бүтцийн нарийвчилсан судалгаа хийж, үйлдвэр болон дамжуулах хоолойн газрын асуудлыг шийдвэрлэнэ.	Тоо хэмжээ: 1 удаа Үйлдвэрийн болон түүхий тос дамжуулах хоолой дамжин өнгөрөх газрыг тухайн орон нутгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан холбогдох хууль, дүрэм, журмын дагуу Улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн байна. Хугацаа: II улирал	ХҮБГ
143.	214.	5.3.2. Газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл, барилгын зураг төслийг боловсруулна. (ЗГҮАХ-2.70.3, ҮЧ-4.4, ТАҮТББ-4.2.3.6)	1. Газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг зохион байгуулна.	Тоо хэмжээ: 1 Нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлийн дундын болон эцсийн тайланг УУХҮЯ-ны ШУТЗ-өөр хэлэлцүүлэн, хүлээж авсан байна. Хугацаа: I улирал	ХҮБГ
	215.		2. Төслийн Байгаль орчин нийгэмд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг боловсруулна.	Тоо хэмжээ: 1 Төслийн Байгаль орчин нийгэмд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг боловсруулсан байна. Хугацаа: Жилдээ	ХҮБГ

144.	216.	5.3.3. Барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтанд оруулна. (ЗГҮАХ-2.70.4, ҮЧ-4.4, ТАҮТББ-4.2.3.6)	1. Барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангана.	Тоо хэмжээ: 1 удаа Барилгын ажлыг эхлүүлэхтэй холбогдуулан геологи, геодези, хөрсний судалгааны ажил, барилгын зураг төслийн ажлыг хийлгэсэн байна. Хугацаа: Жилдээ	ХҮБГ
145.	217.	5.3.4. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн БОННУ-г хүлээн авна. (ЗГҮАХ-2.73.3, ҮЧ-4.4, ТАҮТББ-4.2.3.6)	1. "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн төслийн БОННУ-ний ажилд хяналт тавьж, эцсийн байдлаар хүлээн авах ажлыг зохион байгуулна.	Тоо хэмжээ: 1 Чанар: Мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулсан байна. Хугацаа: III улирал	ХҮБГ
146.	218.	5.3.5.Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулах, холбогдох шийдвэрийг гаргуулах, төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэлийг хангана. (ЗГҮАХ-2.73.4, ҮЧ-4.4, ТАҮТББ-4.2.3.6)	1. "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулж холбогдох шийдвэрийг гаргуулах ажлыг зохион байгуулна.	Тоо хэмжээ: 1 Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн байна. Хугацаа: III улирал	ХҮБГ
	219.		2. Төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг хангана.	Тоо хэмжээ: 1 Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажил хангагдсан байна. Тоо хэмжээ: IV улирал	ХҮБГ
147.	220.	5.3.6. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ, барилгын зураг төсөл боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулна. (ЗГҮАХ-2.73.5, ҮЧ-4.4, ТАҮТББ-4.2.3.6)	1. "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн байршлыг тогтоож, газрыг тухайн орон нутгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан холбогдох хууль, дүрэм, журмын дагуу Улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулна.	Тоо хэмжээ: 1 Чанар: Газрыг Улсын тусгай хэрэгцээнд авсан байна. Хугацаа: II улирал	ХҮБГ
	221.		2. "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн дамжуулах хоолой трассын дагуух газрыг тухайн орон нутгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан холбогдох хууль, дүрэм, журмын дагуу Улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулна.	Тоо хэмжээ: 1 Чанар: Газрыг Улсын тусгай хэрэгцээнд авсан байна. Хугацаа: II улирал	ХҮБГ
	222.		3. "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн төслийн хүрээнд Улаанбаатар хот доторх түгээх сүлжээний нарийвчилсан судалгааг хийж,	Тоо хэмжээ: 1 Чанар: Улаанбаатар хот доторх түгээх сүлжээний нарийвчилсан судалгааг хийсэн байна.	ХҮБГ

			Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулна.	Хугацаа: IV улирал	
	223.		4. "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн төслийн үйлдвэрлэл болон дамжуулахтай холбоотой олон улсын ISO, ГОСТ стандартуудыг орчуулан бэлтгэж, холбогдох журмын дагуу Монгол улсын стандарт болгон батлуулна.	Тоо хэмжээ: 1 Чанар: Монгол Улсын стандарт болгон батлуулсан байна. Хугацаа: III улирал	ХҮБГ
148.	224.	5.3.7. Улаанбаатар хотод жилд 15000 тн тос, тосолгооны материал үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулахыг дэмжинэ. (ЗГҮАХ-2.74.1)	1. Тос тосолгооны материалын эрэлт, нийлүүлтийн чиглэлээр холбогдох судалгааны ажлыг зохион байгуулна.	Тоо хэмжээ: 1 удаа Холбогдох судалгааны ажлыг хийж эхэлсэн байна. Хугацаа: Жилдээ	ХҮБГ
6.0. ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗОХИЦУУЛАХ СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД:					
6.1. Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах гол зорилтын хүрээнд:					
149.	225.	6.1.1. Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд санал дүгнэлт боловсруулна.	1. Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, бодлогын зөвлөмж, санал боловсруулж, холбогдох нэгжид хүргүүлэх	Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Тодорхой ажил зохион байгуулсан байна. Хугацаа: Жилдээ	БХЗГ
150.	226.	6.1.2 Ашигт малтмалын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлттэй холбогдон гарах эрх зүйн бичиг баримтуудыг боловсруулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.	1. Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын төслийг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах /AMTX-10.1.12/	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журам батлагдсан байна. Хугацаа: 3-р улиралд	БХЗГ
	227.		2. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм, шинжээчийн ажлын хөлс тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулах /AMTX-10.1.9/	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журам батлагдсан байна. Хугацаа: 1 улиралд	БХЗГ, ГБГ, УУБГ, ТБГ, ХҮБГ
	228.		4. Үйл ажиллагаагаа эхлүүлэхэд бэлэн болсон уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрүүдийг ашиглалтад хүлээн авах Улсын комиссын үйл ажиллагааг зохион байгуулах /AMTX-35.4/	Тоо хэмжээ: /-/ Чанар: Комисс ажилласан байна. Хугацаа: Тухай бүр	БХЗГ, ХШУДАГ, ТЗУГ
151.	229.	6.1.3. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.	1. Хуулийн үйлчлэлд хамрагдсан тусгай зөвшөөрлүүдийн асуудлыг шийдвэрлэнэ.	Тоо хэмжээ: /-/ Чанар: Шийдвэр гарсан байна. Хугацаа: 4-р улиралд	БХЗГ
152.	230.	6.1.4. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд	1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих,	Тоо хэмжээ: /-/ Чанар: Шийдвэр гарсан байна. Хугацаа: 4-р улиралд	БХЗГ

		хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.	Мэргэжлийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулна.	Чанар: Хяналт тавьж, хуралдааныг зохион байгуулсан байна. Хугацаа: тухай бүр	
	231.		2. Хуулийн этгээдэд хадгалагдаж байгаа болон үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, худалдсан, ашигласан, устгасан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэр төрөл, тоо ширхэг, байршлыг нарийвчлан тусгасан мэдээллийн нэгдсэн сан хөтлөх журмыг боловсруулж, батлуулах.	Тоо хэмжээ: 1 Чанар: Журмыг батлуулсан байна. Хугацаа: 2-р улиралд	БХЗГ
153.	232.	6.1.5. Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн хайгуул судалгаа, ашиглалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. /ЗГҮАХ-2.59.7/	1. Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг цацраг идэвхт ашигт малтмал (уран, тори)-ын хайгуулд хэрэглэх арга зүйн зөвлөмжийн төслийг эцэслэн боловсруулж, ЭБМЗ-өөр хэлэлцүүлнэ.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна. Хугацаа: 2-р улиралд	БХЗГ, ГБГ
	233.		2. Газрын ховор элементийн тусгай зөвшөөрөлтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулна.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Санал боловсруулсан байна. Хугацаа: 4-р улиралд	БХЗГ
154.	234.	6.1.6. Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, эрлийн гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг зохицуулна.	1. “Газрын тосны салбарт төрөөс баримтлах бодлогод газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талаар дэвшүүлсэн бодлогын зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуульд нийцсэн байна. Хугацаа: Жилдээ	БХЗГ, ТБГ
	235.		2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуульд нийцсэн байна. Хугацаа: Жилдээ	БХЗГ, ТБГ
	236.		3. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх харилцааг зохицуулах журам боловсруулна. /ГТБТХ-5.2.3/	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журам батлагдсан байна. Хугацаа: 1 улиралд	БХЗГ, ХҮБГ
6.2. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг гэрээ хэлцэлд бэлтгэх, хэрэгжилтийг зохицуулах гол зорилтын хүрээнд					
155.	237.	6.2.1. Стратегийн орд газарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдтэй төрийн эзэмшлийн хувийг тогтоох хэлэлцээ хийж, улмаар ордыг ашиглах гэрээний төслийг хууль тогтоомжид заасны дагуу бэлтгэх арга хэмжээ авна.	1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын талбайн хил заагийг тогтоох ажлыг зохион байгуулна. /АМТХ-9.1.12/	Тоо хэмжээ: /-/ Чанар: Шийдвэр гарсан байна. Хугацаа: тухай бүр	БХЗГ, УУБГ
	238.		2. Стратегийн ач холбогдол бүхий ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох талаар судалгаа хийж, аж ахуйн нэгжтэй байгуулах хэлэлцээрийн төсөл	Тоо хэмжээ: /-/ Чанар: Санал боловсруулсан байна. Хугацаа: Тухай бүр	БХЗГ, УУБГ, ТЗУГ

			боловсруулна. /АМТХ-5.3, 5.4, 5.5, 8.1.7, 9.1.5, 47 ² /		
156.	239.	6.2.2. Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн нөөц бүхий ордод стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгох, хамтарсан компани байгуулна. /ЗГҮАХ-2.59.9/	1. Орд ашиглах гэрээ байгуулсан Гурвансайхан компанийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг шилжүүлэх, хамтарсан компанийн үйл ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуульд нийцсэн байна. Хугацаа: 4-р улиралд	БХЗГ, ТЗУГ, УУБГ
157.	240.	6.2.3 Гацууртын ордыг эдийн засгийн эргэлтэнд оруулахад дэмжлэг үзүүлэх /ҮЧ-4.3/ /ЭЗСХ-2.2.1.2/	1. Гацууртын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлж, гэрээ байгуулахад хамтран ажиллана.	Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: бодлогын дэмжлэг үзүүлсэн байна. Хугацаа: жилдээ	БХЗГ, УУБГ
6.3. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн бодлого, улсын төсөв, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохицуулалтаар хангах гол зорилтын хүрээнд:					
158.	241.	6.3.3. Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно. /ЗГҮАХ-2.62/	1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын төслийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журам батлагдсан байна. Хугацаа: 1-р улиралд	БХЗГ
159.	242.	6.3.4. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн	1. Хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.	Тоо хэмжээ: /-/ Чанар: Хуульд нийцсэн байна. Хугацаа: тухай бүр	БХЗГ
	243.	холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно. /ЗГҮАХ-2.64.2/	2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж санал боловсруулна.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Зөвлөмж гарсан байна Хугацаа: 4-р улиралд	БХЗГ
160.	244.	6.3.5. Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. /ЗГҮАХ-2.69./	1. Ашиглалтад оруулахад бэлэн болсон алтны уурхай, баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлэх /ЗГҮАХ-2.69.6/	Тоо хэмжээ: /-/ Чанар: Комисс ажилласан байна. Хугацаа: тухай бүр	БХЗГ
	245.		2. Бичил уурхай төвлөрсөн нутаг дэвсгэрт алтны худалдааны нэг цэгийн үйлчилгээ байгуулах талаар судалгаа хийж, хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ-2.69.7/	Тоо хэмжээ: /-/ Чанар: Судалгаа хийсэн байна. Хугацаа: 4-р улиралд	БХЗГ
161.	246.	6.3.6. Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр	1. Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,	Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Шийдвэр гарсан байна. Хугацаа: Жилдээ	БХЗГ

		ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ-2.61/	бодлогын түвшинд нэгдсэн удирдлагаар хангах /ЗГҮАХ-2.61.4/		
6.4. Салбарын статистик мэдээ гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчийг мэдээллээр хангах гол зорилтын хүрээнд:					
162.	247.	6.4.1. Геологи, уул уурхайн салбараас улсын төсөв, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийх, эрдсийн бүтээгдэхүүний үнийн судалгаа хийнэ.	1. Уул уурхайн гаралтай түүхий эдийг эхний ээлжинд дотоодын боловсруулах үйлдвэрт нийлүүлэх боломжийн талаар судалгаа хийж, санал боловсруулах	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Тодорхой санал гарсан байна. Хугацаа: Жилдээ	БХЗГ
	248.		2. Геологи, уул уурхайн салбарт судалгааны ажил хийх зорилгоор хэрэгжүүлэх гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах	Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хамтран ажилласан байна. Хугацаа: Жилдээ	БХЗГ
	249.		3. Уул уурхайн гаралтай эрдэс, түүхий эд, баяжмал бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн судалгаа хийх	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Судалгаа хийгдсэн байна. Хугацаа: Жилдээ	БХЗГ
163.	250.	6.4.2. Уул уурхайн салбарын статистик мэдээ гаргах, мэдээллийн сан бүрдүүлнэ.	1. Уул уурхайн бүтээгдэхүүн олборлолт, экспортын статистик мэдээллийг нэгтгэх, нийтэд ил тод мэдээлэх	Тоо хэмжээ: 12 удаа Чанар: Мэдээлэл үнэн байна. Хугацаа: Сар бүр	БХЗГ
	251.		2. “Мэдээлэл авах тухай” журмыг шинэчлэн боловсруулж, мэдээллийг цахим хэлбэрт оруулах ажлыг эхлүүлэх	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журам батлагдсан байна. Хугацаа: Жилдээ	БХЗГ
164.	252.	6.4.3. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын мэдээллийн нэгдсэн сан байгуулна.	1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын мэдээллийг орд тус бүрээр гаргаж, мэдээллийн сан байгуулна.	Тоо хэмжээ: /-/ Чанар: Мэдээлэл нэгтгэгдсэн байна. Хугацаа: Жилийн турш	БХЗГ
	253.		2. Цацраг идэвхт ашигт малтмалын мэдээллийг орд бүрээр гаргаж, мэдээллийн сан байгуулна.	Тоо хэмжээ: /-/ Чанар: Мэдээлэл нэгтгэгдсэн байна. Хугацаа: Жилийн турш	БХЗГ
165.	254.	6.4.4. Геологи, уул уурхай, газрын тосны салбарт гадаадаас ажиллах хүч авах ажилд хяналт тавьж, мэдээллийн сан бий болгоно.	1. Гадаадаас авах ажиллах хүчний талаар ирүүлсэн хүсэлтийг судалж, холбогдох байгууллагад уламжлах /АХГГАХМАТ-8.2.6, АМТХ-43.1, 43.2/	Тоо хэмжээ: /-/ Чанар: Холбогдох байгууллагад уламжилсан байна. Хугацаа: Тухай бүр	БХЗГ, ТБГ
	255.		2. Гадаадаас авах ажиллах хүчний талаар мэдээллийн санг бий болгох	Тоо хэмжээ: /-/ Чанар: Мэдээлэл нэгтгэсэн байна. Хугацаа: Тухай бүр	БХЗГ
166.	256.	6.4.5. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд олгогдож буй тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, нийтэд ил тод мэдээлнэ.	1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд олгогдож буй тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, нийтэд ил тод мэдээлнэ.	Тоо хэмжээ: /-/ Чанар: Мэдээлэл нэгтгэсэн байна. Хугацаа: Тухай бүр	БХЗГ, ТБГ
	257.		2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох өргөдөлийг хүлээн авч,	Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хүсэлтүүдийг судалж, хариу өгсөн байна. Хугацаа: Жилдээ	БХЗГ, ТБГ

			шийдвэрлэнэ. /ААҮАТЗТХ-15.10.2, 15.10.4, 15.10.13, 15.10.15, 15.10.17-20, 15.10.21/		
7.0. ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНД ҮНЭЛГЭЭ ӨГӨХ, ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ, ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАНД САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТ ХИЙХ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГААР ХАНГАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:					
7.1. Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, хөтөлбөр төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж үр дүнг нь үнэлж дүгнэх, дүгнэлт зөвлөмж гаргах гол зорилтын хүрээнд:					
167.	258.	7.1.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. /ЗГ-2017-89-ийн 8.1., 8.6./	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулж, удирдлагын зөвлөлд танилцуулан, шийдвэр гаргуулан дүнг ЗГ-ын ХЭГ-т хүргүүлнэ.	Тоо хэмжээ: 2 удаа Чанар: Журмын дагуу тайланг хүргүүлсэн байна. Хугацаа: 01/15, 07/01-ний дотор	ХШУДАГ
	259.		2. Хяналтаас хасуулах шийдвэр заалтын жагсаалт гаргаж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлангийн хамт ЗГХЭГ-т хүргүүлнэ.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хяналтаас хасуулах санал үндэслэлтэй байна. Хугацаа: 01/15-ны дотор	ХШУДАГ
168.	260.	7.1.2 “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. /ЗГ-2017-89-ийн 7.5.1./	1. Бодлогын баримт бичгийн I үе шатны зорилтын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж Сангийн яаманд хүргүүлнэ.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журмын дагуу тайланг хүргүүлсэн байна. Хугацаа: 09/01-ний дотор	ХШУДАГ
169.	261.	7.1.3. Салбарт хэрэгжиж буй төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. /ЗГ-2017-89-ийн 7.5.2./	1. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ЗГХЭГ-т хүргүүлнэ.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журмын дагуу тайланг хүргүүлсэн байна. Хугацаа: 04/01-ний дотор	ХШУДАГ
	262.		2. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг удирдлагын зөвлөлийн хурлаар ЗГХЭГ-т хүргүүлнэ.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журмын дагуу тайланг хүргүүлсэн байна. Хугацаа: 04/01-ний дотор	ХШУДАГ
	263.		3. Төрөөс газрын тосны салбарт 2027 он хүртэл баримтлах бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг удирдлагын зөвлөлийн хурлаар ЗГХЭГ-т хүргүүлнэ.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журмын дагуу тайланг хүргүүлсэн байна. Хугацаа: 04/01-ний дотор	ХШУДАГ
170.	264.	7.1.4 Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт,	1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд яамны эрхлэх асуудлаар тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг	Тоо хэмжээ: 2 удаа Чанар: Журмын дагуу тайланг хүргүүлсэн байна. Хугацаа: 02/01, 07/01-ний дотор	ХШУДАГ

		арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. /ЗГ-2017-89-ийн 7.5.3./	удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ЗГХЭГ-т хүргүүлнэ.		
171.	265.	7.1.5. “Алт-2” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. /ЗГ-2017-89-ийн 7.5.4./	1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Монгол банкны ерөнхийлөгчийн хамтран баталсан “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-ний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ЗГХЭГ-т хүргүүлнэ.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журмын дагуу тайланг хүргүүлсэн байна. Хугацаа: 04/01-ний дотор	ХШУДАГ
172.	266.	7.1.6. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. /ЗГ-2017-89-ийн 7.5.6./	1. 2017 оны Үндсэн чиглэлийн биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж Сангийн яаманд хүргүүлнэ	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журмын дагуу тайланг хүргүүлсэн байна. Хугацаа: 01/20-ны дотор	ХШУДАГ
	267.		2. 2018 оны Үндсэн чиглэлийн хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж Сангийн яаманд хүргүүлнэ.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журмын дагуу тайланг хүргүүлсэн байна. . Хугацаа: 06/25-ны дотор	ХШУДАГ
173.	268.	7.1.7. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. /ЗГ-2017-89-ийн 7.5.8./	1. Зээл, буцалтгүй тусламж, хамтарсан төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж Сангийн яаманд хүргүүлнэ.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журмын дагуу тайланг хүргүүлсэн байна. . Хугацаа: 03/01-ний дотор	ХШУДАГ
174.	269.	7.1.8. Тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж нэгдсэн тайланг боловсруулан дүнг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ЗГХЭГ-т хүргүүлнэ. /ЗГ-2017-89-ийн 9.1./	1. Яамны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө /ТШЗ-ийн ҮДГ/-ний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг сайд, удирдлагад танилцуулна.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журмын дагуу тайланг боловсруулж хүргүүлсэн байна. Хугацаа: 04/01-ний дотор	ХШУДАГ
	270.		2. Яамны засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж нэгдсэн тайланд хавсаргана.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журмын дагуу тайланг боловсруулж хүргүүлсэн байна. Хугацаа: 04/01-ний дотор	ХШУДАГ
	271.		3. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж нэгдсэн тайланд хавсаргана.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журмын дагуу тайланг боловсруулж хүргүүлсэн байна. Хугацаа: 04/01-ний дотор	ХШУДАГ
	272.		4. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар	Тоо хэмжээ: 1 удаа	ХШУДАГ

			байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж нэгдсэн тайланд хавсаргана.	Чанар: Журмын дагуу тайланг боловсруулж хүргүүлсэн байна. Хугацаа: 04/01-ний дотор	
175.	273.	7.1.9. ЗГХЭГ-ын даргын баталсан ерөнхий удирдамжийн дагуу Хэрэглэгчийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгүүлж дүнг яамны үйл ажиллагааны нэгдсэн тайланд хавсарган ЗГХЭГ-т хүргүүлнэ. /ЗГ-2017-89-ийн 9.1.1.7./	1. Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх зардлыг яамны төсөвт тусган батлуулсан байна.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Зардлыг тусгаж батлуулсан байна. Хугацаа: /-/	ХШУДАГ
	274.		2. Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх байгууллагыг сонгон шалгаруулна.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Гүйцэтгэх байгууллагыг сонгосон байна. Хугацаа: 2018/03/01-ний дотор	ХШУДАГ
	275.		3. Хэрэглэгчийн үнэлгээний тайланг хүлээн авч, сайд, удирдлагад танилцуулан, яамны нэгдсэн тайланд хавсарган, ЗГХЭГ-т хүргүүлнэ.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Тайланг хүлээн авсан байна. Хугацаа: 2018/04/01-ний дотор	ХШУДАГ
176.	276.	7.1.10. Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сан бүрдүүлнэ.	1. Хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг он тус бүрээр, тайлангийн төрлөөр нь ангилан нэгдсэн файлын сан үүсгэнэ.	Тоо хэмжээ: Тайлан бүрээр Чанар: Файлын нэгдсэн санд мэдээлэл бүрэн орж, зарим мэдээлэл нь хүснэгт, зураг хэлбэрээр байна. Хугацаа: Тухай бүр	ХШУДАГ
177.	277.	7.1.11. Яамны дотоод нэгжүүдийн сар бүрийн хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, тайланг нэгтгэн гаргаж, холбогдох газарт хүргүүлнэ.	1.Сар бүрийн гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.	Тоо хэмжээ: 12 Чанар: Төлөвлөгөөг боловсруулан батлуулсан байна. Хугацаа: Сар бүр	Бүх газар хэлтсүүд
	278.		2. Яамны дотоод нэгжүүдийн сар бүрийн ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг гаргуулан авч нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлнэ.	Тоо хэмжээ: 12 удаа Чанар: Сар бүрийн төлөвлөгөөний биелэлтийг тогтсон хугацаанд хүргүүлсэн байна. Хугацаа: Дараа сарын 05-ны өдрийн дотор	ХШУДАГ, Бүх газар хэлтсүүд
	279.		3. Сар бүр гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэн гаргаж ХШУДАГ-т хүргүүлэх.	Тоо хэмжээ: 12 Чанар: Төлөвлөгөөг боловсруулан батлуулсан байна. Хугацаа: Сар бүр	Бүх газар хэлтсүүд
7.2. Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, гэрээний хэрэгжилт болон иргэд байгууллагын мэдээлэл, өргөдөл гомдлын мөрөөр дотоодын хяналт, шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт гаргах гол зорилтын хүрээнд:					
178.	280.	7.2.1. Иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн гомдлын мөрөөр дотоодын хяналт, шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгнө. /ЗГ-2012-63/10/-ийн 2.5.4.2/	1. Иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн гомдлын мөрөөр дотоодын хяналт, шалгалт хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, удирдлагад танилцуулан хариуг иргэн, аж ахуйн нэгжид хүргүүлнэ.	Тоо хэмжээ: /-/ Чанар: Хяналт шалгалтыг зохион байгуулж, хариуг хүргүүлсэн байна. Хугацаа: Тухай бүр	ХШУДАГ
179.	281.	7.2.2. Шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн	1. Эрх зүйн акт болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг газар дээр нь	Тоо хэмжээ: /-/ Чанар: Хяналт шалгалтыг зохион байгуулж, хариуг хүргүүлсэн байна. Хугацаа: Тухай бүр	ХШУДАГ

		хэрэгжилт, харъяа байгууллагын үйл ажиллагааг газар дээр нь шалгаж, тайлан, мэдээллийг нь хэлэлцэн, тэдгээрийн мөрөөр холбогдох арга хэмжээг авна. /ЗГ-2017-89-ийн 7.3, 8.7, 9.5, 11.3.3./	шалгаж, тайлан, мэдээллийг нь хэлэлцэж дүгнэлт, зөвлөмж боловсруулж, удирдлагуудад танилцуулна.	Чанар: Цаашид авах арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулж, удирдлагыг эрсдэлийн удирдлагаар хангасан байна. Хугацаа: Тухай бүр	
180.	282.	7.2.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана. /Шилэн дансны тухай хуулийн 8.2., Төсвийн тухай хуулийн 69.1/	1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд өдөр тутмын хяналт тавина.	Тоо хэмжээ: Сар бүр Чанар: Шаардлагатай мэдээллийг байршуулж хэвшүүлнэ. Хугацаа: Тухай бүр	ХШУДАГ
181.	283.	7.2.4. Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	1. Салбарын гол хуулиудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулан удирдлагад танилцуулна.	Тоо хэмжээ: /-/ Чанар: Цаашид авах арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулж, удирдлагыг эрсдэлийн удирдлагаар хангасан байна. Хугацаа: Тухай бүр	ХШУДАГ
7.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээний яам, байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах гол зорилтын хүрээнд:					
182.	284.	7.3.1. Төсвийн шууд захирагч нарын Үр дүнгийн гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	1. Төсвийн шууд захирагч /УУХҮЯ-ны ТНБД/-ын 2018 оны Үр дүнгийн гэрээний биелэлтэд салбар, нэгж бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж боловсруулж Сайдад танилцуулна.	Тоо хэмжээ: 2 удаа Чанар: Ажил үйлчилгээг бүрэн хамарсан байна. Хугацаа: 06/25, 12/25-ны дотор	ХШУДАГ
	285.		1. Төсвийн шууд захирагч /АМГТГ-ын дарга/-ын 2018 оны Үр дүнгийн гэрээний биелэлтэд салбар, нэгж бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулж Сайдад танилцуулна.	Тоо хэмжээ: 2 удаа Чанар: Ажил үйлчилгээг бүрэн хамарсан байна. Хугацаа: 06/25, 12/25-ны дотор	ХШУДАГ
183.	286.	7.3.2. Ажлын хэсгийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. /УУХҮС-2017-А/122--ын 9.11/	1. Сайд, ТНБД-ын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгүүдийн ажлын явц, хүрсэн үр дүнгийн тайланг ТЗУГ-аас улирал бүр авч үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулж Сайд, ТНБД-д танилцуулна.	Тоо хэмжээ: 4 удаа Чанар: Ажлын хэсэг бүрийг хамарсан байна. Хугацаа: Дараагийн улирлын эхний сарын 10-ны дотор	ХШУДАГ
184.	287.	7.3.3. Сайдаас аймаг, нийслэлийн Засаг даргатай нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	1. Гэрээний биелэлтийг жилийн эцсийн байдлаар хүлээн авч, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулан яамны нэгдсэн тайланд	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан бүх гэрээг хамарсан байна. Хугацаа: 04/01-ний дотор	ХШУДАГ

		/ЗГ-2017-89-ийн 9.11/	хавсарган удирдлагуудад танилцуулж ЗГХЭГ-т хүргүүлнэ.		
185.	288.	7.3.4. Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	1. төлөвлөгөөнд яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилтот ажлуудын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг уирдлагад танилцуулна.	Тоо хэмжээ: 2 удаа Чанар: Дүгнэлт зөвлөмжийг удирдлагад танилцуулсан байна. Хугацаа: Тухай бүр	ХШУДАГ
7.4. Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ, үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж гаргах гол зорилтын хүрээнд:					
186.	289.	7.4.1. Дотоод аудитын төлөвлөгөөг батлуулна.	1. Сайдын багцад хамаарах байгууллага, төсөл арга хэмжээ, холбогдох байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийх дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулж батлуулна.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Төлөвлөгөөг батлуулсан байна. Хугацаа: 1-р улиралд	ХШУДАГ
187.	290.	7.4.2. Салбарт хэрэгжиж буй төслүүдийн гүйцэтгэлд санхүүгийн дотоод аудит хийнэ.	1. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй геологи хайгуулын төслүүдийн санхүүжилт, гүйцэтгэлд төсөл тус бүрээр дотоод аудит хийж дүнг яамны удирдлагад танилцуулна.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Төслүүдийг бүрэн хамруулсан байна. Хугацаа: Аудитын төлөвлөгөөнд заасан хугацаанд	ХШУДАГ
188.	291.		2. Гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжиж буй төслүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнд дотоод аудит хийж дүнг яамны удирдлагад танилцуулна.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Төслүүдийг бүрэн хамруулсан байна. Хугацаа: Аудитын төлөвлөгөөнд заасан хугацаанд	ХШУДАГ
189.	292.	7.4.3. Салбарт хэрэгжүүлэх улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтэд төсөл арга хэмжээ бүрээр дотоод аудит хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулж дүнг төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулна.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Арга хэмжээ бүрийг хамарсан байна. Хугацаа: Аудитын төлөвлөгөөнд заасан хугацаанд	ХШУДАГ
190.	293.	7.4.4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	1. Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд арга хэмжээ бүрээр дотоод аудит хийж, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулж дүнг төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулна.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Арга хэмжээ бүрийг хамарсан байна. Хугацаа: Аудитын төлөвлөгөөнд заасан хугацаанд	ХШУДАГ
191.	294.	7.4.5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсвийн орлого, зарлагын тооцоолол, санхүүжилтийн гүйлгээ, төсвийн тайлан тэнцэлд санхүүгийн дотоод аудит хийнэ.	1. Холбогдох материалыг цуглуулах, нягтлах, газар дээр шалгаж аудитын дүгнэлт, санал зөвлөмжийг боловсруулж төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулна.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: ТЭЗ-ийг эрсдэлийн удирдлагаар хангасан байна. Хугацаа: Аудитын төлөвлөгөөнд заасан хугацаанд	ХШУДАГ

192.	295.	7.4.6. Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын хүний нөөц, боловсон хүчний чиглэлээр батлагдсан тушаал шийдвэр, бусад дүрэм, журмын хэрэгжилтэд нийцлийн аудит хийнэ.	1. УУХҮЯ, АМГТГ-т төрийн алба, хүний нөөцийн чиглэлээр батлагдсан хууль тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж дүгнэлт зөвлөмж боловсруулж дүнг удирдлагын зөвлөлд танилцуулна.	Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Удирдлагыг эрсдэлийн удирдлагаар хангасан байна. Хугацаа: Аудитын төлөвлөгөөнд заасан хугацаанд	ХШҮДАГ
193.	296.	7.4.7. Хэрэгжүүлэгч агентлагийн үйл ажиллагаанд хяналт тавих.	1. Агентлагийн санхүү аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд тавьж ажиллана.	Тоо хэмжээ: /-/ Чанар: Илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Хугацаа: Аудитын төлөвлөгөөнд заасан хугацаанд	ХШҮДАГ
194.	297.	7.4.8. Сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт шалгалт, дотоод аудит тухай бүр хийнэ.	1. Сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийж дүгнэлт, зөвлөмж гарган яамны удирдлагад танилцуулна.	Тоо хэмжээ: /-/ Чанар: Удирдлагыг эрсдэлийн удирдлагаар хангасан байна. Хугацаа: Тухай бүр	ХШҮДАГ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

Г.НАНДИНЖАРГАЛ